

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр, Пүрэв гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-6
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	7-17

-
- | | |
|--|------|
| 1. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/ | 7-17 |
|--|------|
-

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
11 дүгээр сарын 20-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 53.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 28 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Бейсен, Б.Бат-Эрдэнэ, Г.Ганбаатар, Д.Жаргалсайхан, Р.Сэддорж;

Чөлөөтэй: С.Амарсайхан, О.Амгаланбаатар, П.Батчимэг, С.Ганбаатар, З.Мэндсайхан, А.Ундраа;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Чинбүрэн.

Нэг. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, мөн газрын Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Золбоо, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, мөн газрын Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Төгөлдөр, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Б.Энхгэрэл нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, Л.Мөнхбаясгалан, С.Замира нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Төгөлдөр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Идэрбат: 1.Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн “НИЙГМИЙН

ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ” бодлогын чиглэлийн 3.1.2 дахь дэд заалтын “хамтран хариуцагч” баганад “Боловсролын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн “НИЙГМИЙН ХӨГЖИЛ, ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ” бодлогын чиглэлийн 4.4.3 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад” Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам” гэсний дараа “ , Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн “ЭДИЙН ЗАСАГ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ” бодлогын чиглэлийн 5.1.2.1 дэх дэд заалтын “Арга зам” баганад “нийлүүлэлтийн сүлжээг өргөтгөх” гэсний дараа “ , хүний нөөцийг бэлтгэх /анхан, дунд, дээд шатанд/, ажлын байрыг баталгаажуулах” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай үг хэлэв.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн “ЭДИЙН ЗАСАГ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ” бодлогын чиглэлийн 5.3.1.2 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Шадар сайдын ажлын алба /Бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн/” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн “ЭДИЙН ЗАСАГ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ” бодлогын чиглэлийн 5.3.1.3 дахь дэд заалтын “Арга зам” баганад “Дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх” гэсний дараа “ , хөрсний

үржил шимийг сайжруулах, ган, чийгт тэсвэртэй үр сортыг бий болгож, тариалах” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн “ЭДИЙН ЗАСАГ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ” бодлогын чиглэлийн 5.4.1.1, 5.4.1.2 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Боловсролын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн “БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ЭДИЙН ЗАСАГ” бодлогын чиглэлийн 6.3.1.1 дэх дэд заалтын “Арга зам” баганад “Олон талын оролцоонд суурилсан ой хамгааллыг дэмжих” гэсний дараа “, доройтсон бэлчээрийг ойжуулах ойн бэлчээр үүсгэн, уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах шингээлтийг нэмэгдүүлэх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн “БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ЭДИЙН ЗАСАГ” бодлогын чиглэлийн 6.3.1.2 дахь дэд заалтын “Арга зам” баганад “усны нөөцийн зохистой ашиглалтыг дэмжих” гэсний дараа “, нэн ховор болон ховордсон загасыг унаган орчинд нь нөхөн сэргээх, үржүүлэх” гэж, “Хамтран хариуцагч” баганад “Эрчим хүчний яам” гэсний дараа “Боловсролын яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн “БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ЭДИЙН ЗАСАГ” бодлогын чиглэлийн 6.3.1.5 дахь дэд заалтын “Арга зам” баганад “дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх” гэсний дараа “/Мал бордох аж ахуй, малчдын бууцаар органик бордоо үйлдвэрлэх цех, үйлдвэрүүдийг орон

нутагт байгуулах, үйлдвэрлэсэн бордоогоор нь бэлчээр болон тариалангийн талбайн хөрсөө бордох, үржил шим, бүтээмжийг нэмэгдүүлэх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 5

Бүгд: 18

72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн “ЭДИЙН ЗАСАГ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ” бодлогын чиглэлийн 5.3.1.2 дахь дэд заалтын “Арга зам” баганад “Селекц, үржил, генетикийн хяналтыг сайжруулах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх” гэснийг “Бэлчээр тэжээлийн нэг болон олон наст ургамлын үрийн генфондыг бий болгох, үр үйлдвэрлэлийг хөгжүүлэх, тэжээлийн таримлын технологийг нэвтрүүлж, малын тэжээлийн баазыг бэхжүүлэх, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, шинжлэх ухааны үндэслэлтэй тэжээл үйлдвэрлэлийг хөгжүүлж, нэгж бүтээгдэхүүнд зарцуулах тэжээлийн зардлыг бууруулахад чиглэсэн дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх, нутагшуулах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 5

Бүгд: 18

72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангийн гаргасан, Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 6.3.1.6 дахь дэд заалт нэмэх:

Төслийн 2 дугаар хавсралтын үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн “БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ЭДИЙН ЗАСАГ” бодлогын чиглэлийн “Дугаар” баганад “6.3.1.6” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “АХ-6.3” гэж, “Салбар” баганад “71404 Усны нөөц, нуур, гол мөрний менежмент” гэж, “Үр дүн” баганад “Экологийн тогтвортой байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн хөв цөөрөм, усан сан, нуур байгуулна.” гэж, “Арга зам” баганад “333 нуур-нэг сум, нэг нуур-усны нөөцийн хуримтлал бий болгож уур амьсгалын өөрчлөлтөөс сэргийлэх” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам” гэж, “Хамтран хариуцагч” баганад “Усны газар” гэж, 3 дугаар хавсралтын үндсэн чиглэлийн хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг тодорхойлсон хүснэгтийн “БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ЭДИЙН ЗАСАГ” бодлогын чиглэлийн “Дугаар” баганад “6.3.1.6” гэж, “Салбар” баганад “71404 Усны нөөц, нуур, гол мөрний менежмент” гэж, “Үр дүн” баганад “Экосистемийн тогтвортой байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн хөв цөөрөм, усан сан, нуур” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Шинээр байгуулсан хөв цөөрөм, усан сан, нуур” гэж, Тогтвортой хөгжлийн зорилтын уялдаа” баганад “13.1” гэж, “Хэмжих нэгж” баганад “Тоо” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2025, Түвшин: 4” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026 онд 54, 2027 онд: 104, 2028 онд: 154, 2029 онд: 204, 2030 онд 259” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Мэдээлэх, цуглуулах арга зүй: Салбарын статистик, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангийн гаргасан, Төслийн 4 дүгээр хавсралтын 4.3 дахь хэсэгт заасан жагсаалтад доор дурдсан агуулгатай 13 дахь мөр нэмэх:

“НОГООН ХӨГЖИЛ” хэсгийн “Дугаар” баганад “13” гэж, “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “333 нуур-нэг сум, нэг нуур-усны нөөцийн хуримтлал” гэж, “Байршил” баганад “Улсын хэмжээнд” гэж, Санхүүжилтийн хугацаа” баганад “2026-2030”, “Төсөвт өртөг” баганад “201,600.0” гэж, “Хариуцагч” баганад “Байгаль орчин, уур амьсгалтын өөрчлөлтийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 44 минут үргэлжилж, 30 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 13 цаг 12 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
12 цаг 28 минут.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Ц.Идэрбат: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 53,3 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааныг эхлүүлье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүний сонгогдсон тойрог, нэрээр нь танилцуулна.

Наранцэцэгийн Алтаншагай, Гонгорын Дамдинням, Цагаанхүүгийн Идэрбат, Цагаанхүүгийн Мөнхбат, Баатаржавын Мөнхсоёл, Цэвэгдоржийн Туваан, Жигжидийн Батжаргал, Сонгобайн Замира, Сүрэнжавын Лүндэг, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Нанзадын Наранбаатар, Болдын Уянга, Мөнгөнцогийн Ганхүлэг, Жаргалсайханы Золжаргал, Мэндбаярын Мандхай, Тогтмолын Мөнхсайхан, Салдангийн Одонтуяа гэсэн гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх 1 асуудал байгаа.

1.“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 10 сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ бид Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулъя. Ж.Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Г.Дамдинням Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Ш.Мөнхцэрэн Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга, Б.Золбоо Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Сангийн яамнаас Санжаадорж Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Ж.Дэлгэржаргал Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас Ш.Батбаяр Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Г.Энхмөнх Хүрээлэн буй орчны бодлого, үнэлгээний газрын дарга, Энэ хүмүүс маань байгаа биз. Т.Балжинням Байгалийн нөөцийн бодлого, зохистой ашиглалтын газрын дарга, Б.Оюунсанаа Ойн газрын дарга, З.Батбаяр Усны газрын дарга, С.Эрдэнэцэцэг Байгаль орчны нэгдсэн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Ерэн-Өлзий ийм ажлын хэсгийн бүрэлдэхүүн хүрэлцэн ирсэн байна.

Хэлэлцэх асуудлыг танилцуулсан. Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу. Байхгүй байна. Хэлэлцэх асуудлаа баталъя. Хэлэлцэх асуудалдаа оръё.

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж анхны хэлэлцүүлэгт бэлд бүрдүүлэхээр Эдийн засгийн байнгын хороо болон бусад Байнгын хороодод шилжүүлсэн байгаа. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Нэрсээ өгөөрэй. Ганхүлэг гишүүнээр тасаллаа. Ганхүлэг гишүүн.

М.Ганхүлэг: ийм Нэлээн детальчлаад бас ярих юмнууд бас байгаа. Энхбаяр сайдаас ирэх 5 жилийн хугацаанд бүсчилсэн хөгжлийн гол концепцууд тэр дундаа зүүн бүс нутаг, Хэнтий, Дорнод, Сүхбаатар дээр нийт мал сүргийн 30 гаруй хувь бараг байгаа байх. Бэлчээр тэжээлийн, мал аж ахуйн салбарын бол бас нэлээн суурь тавлаг ийм нөхцөл байдал бүрдсэн ийм бүс нутаг. Бүсчилсэн хөгжлийн гол зорилтын хүрээнд бол бид бүхэн 2024 онд гол мессеж бол түүхэн аялал жуулчлал. Мөн дээрээс нь эрчимжсэн хөдөө аж ахуй гэж томьёолоод байгаа юм.

Тэгэхээр эрчимжсэн хөдөө аж ахуй гэдэг энэ гол агуулгыг бид нар юугаар хэмжих вэ, ирэх 5 жилд тодорхой бас малчид, иргэддээ ямар амлалтуудыг бид бүхэн бас өгөх вэ. Бидний удаа дараа тавиад байгаа гол агуулга бол энэ боомтуудынхаа нэвтрэх чадвар юмнуудыг нэлээн сайжруулъя. Ялангуяа бид булангийн орнуудад бас махны экспорт нэлээн давуу байдалтай. Зүүн бүс нутаг гол бас экспорт дээр тодорхой ахицыг гараад явж байгаа. Тэндээс шууд онгоцоор тээвэрлэх, мөн хил дагуу байгаа малчид заавал ч үгүй Улаанбаатар хот руу тодорхой хэмжээнд тээвэр хийлгүйгээр ойрхон байгаа энэ улсууд руугаа бас экспорт хийх энэ боломжуудын тухай бид бүхэн бас яриад байгаа. Энэ хөдөө аж ахуйн салбарын экспорттой холбогдолтой асуудлыг Эдийн засаг, хөгжлийн яам хариуцаж явахаар байна уу. Эсвэл Сангийн яам хариуцахаар байна уу. Эсвэл яг Хөдөө аж ахуйн яам хариуцахаар байна уу. Нөгөө улсуудын протокол дээр яг хойноос нь хөөцөлдөөд, болохгүй байгаа асуудлуудынх нь хойноос нь яваад байдаг дээр ийм нэгдсэн бүтцийн зохион байгуулалт руу бас орох ёстой юу гээд ийм асуултууд бас байгаа. Тэгэхээр энэ дээр илүү тодорхой асуултуудыг асууя.

Ирэх 5 жилд Зүүн бүс нутаг түүхэн аялал жуулчлал дээр нэмээд мал аж ахуйн эрчимжсэн ийм бүс нутаг болох тодорхой зорилтуудыг бас хэрхэн тусгаж байгаа вэ. Юугаар хэмжих вэ. Энэ асуултуудыг та бүхэн маань дэлгэрэнгүй сайхан хариулж өгөөч ээ.

Ц.Идэрбат: Ганхүлэг гишүүний асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Энхбаяр хариулна. 5 номерын микрофоныг нээе.

Ж.Энхбаяр: Их чухал асуудал. Зүүн бүс нь өөрөө Монгол Улсын ирээдүйн гол үүц. Экспортын чиг баримжаатай, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх гол бүс нутаг. Нөгөө талаар Монголын чиглэсэн түүхэн аялал жуулчлалын гол урсгал. Үүнийг дагаад хоол хүнсний хангамжаас авхуулаад олон зүйл төлөвлөөд, бодоод байгаа боловч харамсалтай нь хөгжлийн яаман дээр бүгд хасагдчихсан байгаа. Манай 10 гаруй гол бодлогын асуудал бүгд хасагдсан. Тэгэхээр Хөгжлийн яам яагаад хассанаа би бас хэрүүл хийгээд сууж байна л даа.

Засгийн газар дээр хэлэлцээд, манай асуудлыг дэмжээд явах ёстой гэсэн асуудлууд сая ингээд би харсан чинь бүгдийг нь хассан, хассан, хассан гээд ороод ирж байна. Энэ дотор нөгөө сүү сүүн бүтээгдэхүүний кластер байгуулах, эрчимжсэн аж ахуй байгуулах, нөгөө тэжээлийн таримлуудыг нэмэгдүүлэх, шинээр газар эзэмших манай салбарын хөгжлийн бодлогуудыг үндсэндээ бодлогоор Хөгжлийн яам хассан байна. Тэгээд гадаадын 3 төсөл байна. Энийг хэрэгжүүлж гэдэг ирэх 5 жилийн хийх ажил бол 3 төсөлтэй. Тэгээд бэлчээрийн ус хангамжийг нэмэгдүүлэх гэж худаг ус гарах ажилтай. Бусад ажлыг Хөдөө аж ахуйн яам хийх шаардлагагүй гэж үзэж байгаа юм байна лээ. Тэгэхээр хөгжлийн яам хариулах байх. Үндэслэл, яагаад хассанаа сайхан тайлбарлаж өг.

Ц.Идэрбат: Энхбаяр сайд баярлалаа. Хөгжлийн яамнаас хэн байгаа билээ. Сүүлд орж ирсэн. Саяын Ганхүлэг гишүүний асуултад Энхбаяр сайдын хэлсэн энэ ирэх 5 жилийн төлөвлөгөөнд тусгагдахаар саналаа өгсөн Хүнс, хөдөө аж ахуйн яамны энэ томоохон төсөл, хөтөлбөрүүдийг яагаад хассан талаар маш тодорхой тайлбараа Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Сүрэнхорол 7 номер та хариул. 8 номер. Албан тушаалаа хэлээрэй.

Л.Энх-Амгалан: Эдийн засаг, хөгжлийн яам Энх-Амгалан. Макро эдийн засгийн бодлогын газрын дарга.

Тодорхой төслүүдийг яг харсан шалтгааныг бол яг төсөл төслөөр нь би хэлж мэдэхгүй байна. Гэхдээ ирэх таван жилд Хөдөө аж ахуйн салбар дээр ямар бодлого баримтлах талаар хэрхэн яригдсан талаар танилцуулъя. Энд 5 жилийн төлөвлөгөөг бол Засгийн газар дээр хэлэлцээд, ингээд өргөн барьсан. Энд бол учиргүй яамнууд хоорондоо хассан, нийлсэн дээрээ хоорондоо ярина уу гэхээс энд учиргүй тайлбар хийх нь зөв биш байх гэж бодож байна. Тэгээд Хөдөө аж ахуйн салбарт олон хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа. Хүнсний хувьсгал, Цагаан алт, Атар гээд. Мөн олон бүтээгдэхүүн дээр татаас өгч байдаг. Манай яамны зүгээс яам хооронд явдаг бичиг дээр ч тэр, яг бодлогын түвшинд бол хөдөө аж ахуйн салбар дэмжлэг мэдээж хэрэгтэй. Гэхдээ энэ дэмжлэг нь санаачлагдсан бол .../минут дуусав/

Ц.Идэрбат: 8 номерын микрофон хариултыг гүйцээж авъя.

Л.Энх-Амгалан: Дэмжлэгүүд бол хэрэгтэй. Гэхдээ дэмжлэг хэзээ дуусах нь өөрөө тодорхой байх ёстой. Ингээд дуусахгүй үргэлжлээд, нэрээ солиод л үргэлжлээд л хэрэгжээд байх нь өөрөө зах зээл дээр салбартаа, салбарынхаа компаниудыг ямар нэгэн дэмжлэггүй л бол банктэй харьцаж зээл авч чадахгүй болтол нь тийм бээвгэр байдалд оруулаад байгаа. Тэгэхээр ямар нэгэн татаас дэмжлэгийн хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа бол яаж дуусах стратеги нь тодорхой байх ёстой. Хэзээ дуусах нь бас тодорхой байх ёстой. Дуусах цаг хугацаа болоход эцэст нь тэр компаниуд аливаа дэмжлэггүйгээр банктэй харьцаад зах зээлийнхээ зарчмаар хөгжөөд явдаг болно гэсэн тийм итгэл үнэмшилтэйгээр хөтөлбөрүүд хэрэгжих хэрэгтэй гэдэг л ийм л байр суурьтай байгаа.

Тэгэхээр ирэх 5 жилд бол одоо хэрэгжиж байгаа хөтөлбөрүүд аль болох зөв стратегиар дуусаад, үргэлжлэх нь бол хэзээ болтол үргэлжлэх нь тодорхой болоод ингээд хэрэгжээд эцэст нь хөдөө аж ахуйн салбар .../минут дуусав/

Ц.Идэрбат: 5 номер Энхбаяр сайд нэмээд тайлбарлачихъя.

Ж.Энхбаяр: Энэ залуу дарга ерөөсөө ажлаа ойлгоогүй хүн байна. Энэ чинь Их Хурлын тогтоолтой, хуульчлагдсан. 2028 он хүртэл хэрэгжих үндэсний хөдөлгөөнүүд шүү дээ. Төрийн тэргүүн санаачлаад, Их Хурал тогтоол гаргаад, Засгийн газар хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүд байхгүй юу даа. Одоо 2026, 2027, 2028 он хүртэл энэ чинь явах ёстой ажил. Гэтэл овоо нэг яваад, эдийн засагт нөлөөлөх нөлөөлөл нь нэмэгдээд, өдөр болгон шинэ үйлдвэр нээгдэж байна шүү дээ.

Сая 3 дугаар улирлын статистик мэдээ гарлаа. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар 33.8 хувийн өсөлт үзүүлээ. ДНБ-ий өсөлтийн бараг 60 хувийг энэ салбар чинь хангаад гараад ирлээ. 48 мянган ажлын байр шинээр бий болгоод ороод ирэхэд энэ бодлогыг хийж байгаа яамны ийм мэтийн ийм түшмэд үзэмжээр хасаж эхэлж байгаа байхгүй юу. Тэгэхээр бил бол Байнгын хороонд хүсэж байна. Энийг дахин авч үзээч ээ. Юу гэсэн үг вэ энэ чинь. Нөгөө эрчимжүүлэлт, хөгжүүлэлт, атрын газрын эзэмших энэ чинь бүгд .../минут дуусав/

Ц.Идэрбат: Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Бүрэн хариултаа авч чадахгүй л байгаад байна л даа. Би бүсчилсэн хөгжлийн тухай, зүүн бүс нутагт түүхий аялал жуулчлалын бүс нутаг болон хөгжих болно эрчимжсэн мал аж ахуйг бид нар дэмжинэ гэсэн ийм агуулга байгаа. Тэгээд энэ дээр яг тодорхой ямар төлөвлөгөөг ирэх таван жилд тусгаад байгаа юм бэ. Ямар үр дүнг бид нар амлах юм бэ гэдэг ийм л ерөнхий асуулт. Бүр детальчлаад, тэр хилийн боомтуудыг, аль аль боомтуудыг нээх юм. Ямар үйлдвэрүүд байгуулагдах юм. Тодорхой хэмжээнд энэ ажлууд дээр яаж төлөвлөгдөх юм энэ тэр гээд бүр детальчлаад асуувал та хэд бүр балрах юм байна л даа. Тэгэхээр бид нарын яг гол ярьж байгаа асуудал энэ асуудлынхаа гүн лүүгээ яагаад орохгүй байна вэ. Ирэх 4, 5 жилд хөдөө аж ахуйн гаралтай энэ түүхий эд экспортын асуудлыг яг хаана хариуцах юм бэ. Аль албан нэгж дээр ямар зорилт тавьж ажиллах юм бэ л гэдэг ийм асуултуудыг асуугаад байна шүү дээ.

Ц.Идэрбат: Ажлын хэсгийн Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Энх-Амгалан дарга та бас тийм дураараа юм ярьж болохгүй.

Улсын Их Хурал, Байнгын хороо дээр энд ярих асуудал биш гэж. Та хаана ярих гээд байгаа юм тэгээд. Тэгээд яриад орж ирж байгаа юм чинь ямархуу юм орж ирж байгаа юм. Тодорхой үр дүн гаргаж байгаа төслүүдийг хасна гэсэн ийм таван жилийн төлөвлөгөө. Наадах чинь 5 жил гэж байгаа боловч сарын дараа хэрэгжих төлөвлөгөө шүү дээ. 2026 оноос. Тэгэхээр ийм чухал асуудлыг Монгол Улсын хөдөө аж ахуйн салбартай өсөлт хөгжилттэй тэр салбарт ажиллаж байгаа, тэр салбараас хоолоо залгуулж байгаа Монголчуудын асуудлыг та энд ярихгүй. Энд ярьдаг газар нь биш гэж ингэж маш том үг яриад сууж байгаад харамсаж байна. Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Хөдөө аж ахуйн чиглэлээр мал, малчны чиглэлээр асуух гэсэн тэгээд хасагдчихсан юм биш биз дээ арай. Би асуултаа асууя.

Малчид орлогогүй байгаа нь, малчид ядуу байгаа нь түрүүний Ганхүлэг гишүүний хэлснээр тэр хаа холын сумаас малынхаа махыг бариад, хотод ирж зарах уу. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх ёстой гэж ярьж байгаа. Бэлчээрийн мал аж ахуйгаа яах юм бэ. Уламжлалт мал аж ахуй маллаж, амьдарч байгаа малчин

иргэдээ яаж орлогожуулах юм. Энэ таван жилийн төлөвлөгөөнд, үндсэн чиглэлд яг ямар байдлаар хөгжүүлнэ гэж заасан бэ.

Мөн говийн бүсэд чиглэсэн тариалан дээрээс нь мал аж ахуйн чиглэлээр ямар асуудлууд тусгагдсан бэ. Мал, малчин, нүүдлийн мал аж ахуй 3 бол Монгол Улсын яг оршихуй байхгүй юу. Үндэс нь байхгүй юу. Тэгэхээр энийг онцгойлон анхаарсан байх гэж би бодож байна. Асуултдаа хариулт авъя.

Ц.Идэрбат: 5 номерын микрофон. Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Малчдын орлого, малчид орлоготой байж байж мал аж ахуй эрхлэх дур сонирхолтой. Нутаг орон эзэнтэй, Монгол Улс газар нутгаа хянаж чадах юм. Мэдээж газар тариалангийн гол бүс нутгаа тулгуурлаж эрчимжсэн аж ахуйнуудыг хөгжүүлж, төвлөрсөн хүн амынхаа хүнсний хэрэглээг хангах нь зайлшгүй. Нөгөө талаар уламжлалт мал аж ахуйгаа энэ байгаль цаг уурын эрс тэс өөрчлөлтөд дасан зохицох, даван туулах чадавхыг бий болгохын тулд энэ Атрын 4 гэдэг аяны хүрээнд тэжээлийн таримлыг эрс нэмэгдүүлэх бодлого яваад байгаа юм. Бүх орон нутаг тэжээлийн таримлыг бий болгох. Өөр өөрийн онцлогт таарсан. Ийм учраас 200 мянган га талбайг нэмж эргэлтэд оруулъя гэдэг зорилт батлагдаад явж байгаа байхгүй юу.

Нэг талаар малын тоо 25 сая толгойгоор даац хэтэрсэн. Тэгэхээр яамны бодлого бол экспортыг бүх талаар урамшуулах бодлого хийж байна. Экспорт. Яг өнөөдрийн байдлаар 270-аад сая долларын мах экспортод гарчхаад байна. Он дуусахад бид нар 300 сая доллар давуулчихна. Ийм гэрээ хэлэлцээрүүд хийгдээд явж байна. Ингэснээр экспортод гарч байж ер нь түүхий эдийн л үнэ цэн өснө. Тэрнээс энэ дотор 3,5 сая хүний зах зээлдээ нийлүүлэлт дээр байгаад байвал үнэ өсөхгүй, үнийн байнгын хямд байдал хангаад байгаа. Иймд бид нар яг бүх салбарын хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт дээр гол бодлого явуулж байгаа юм. Энэ хөтөлбөр, энэ зорилгыг хангахын тулд Цагаан алт хөтөлбөр, Атрын 4 дүгээр аян, Хүнсний хувьсгал чинь яваад байгаа юм.

Харамсалтай нь энэ тариалангийн зориулалттай тэжээлийн энэ талбай нэмэх энэ бодлого, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, мал аж ахуйн эрсдэлээс хамгаалах энэ бодлогыг бас хасчихсан. Тэгээд би ерөөсөө ойлгохоо больчихоод байгаа байхгүй юу. Гадаадын 3 зээл тавьчихсан байна. Энийг хэрэгжүүл гэдэг ийм хөтөлбөртэй. Засаг дээр яригдсан яамны бүх бодлогуудыг хасчхаад ороод ирчхээд, тэгээд би асуугаад байна. Хэн нь хөдөө аж ахуйн хүн бэ. Хэн нь хөдөө төрж өссөн хүн бэ. Энэ мал аж ахуй, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр мэддэг хүн байна уу?. Байдаг бол би ингээд мэддэг юм, та буруу ярьж байна гээд надтай нэг яриадхаач. Хөгжлийн яамныхан баахан макро, микро яриад байх юм.

Ц.Идэрбат: Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: Малын махыг малаас гарч байгаа бүтээгдэхүүнийг экспортолж байж орлого өснө. Тэрийг бид нар сүүлийн бараг 20 гаруй жил ярьсан. Цагаан алд хөтөлбөр эд нар гээд л яриад байгаа. Яг хэрэгжээд, жишээ нь би говийн бүсийг асуугаад байна л даа. Говийн бүсэд яг энэ 5 жилд юу хийхээр төлөвлөсөн юм бэ. Хамгийн их уур амьсгалын өөрчлөлтөд орж байгаа, цөлжилтөд нэрвэгдэж байгаа бүс нутаг. Манай говийн бүсийн малчид яах юм. 5 мянган жилийн түүхтэй уламжлалт мал аж ахуй л даа. Бид нар энэ хатуу ширүүн уур амьсгалдаа дасан

зохицоод, ажиллаад, амьдраад ирчихсэн. Яах вэ сүүлийн 10-аад жилээс авхуулаад уур амьсгалын өөрчлөлтөд нэрвэгдэж байгаа.

Тэгэхээр Энхбаяр сайд аа, Хөгжлийн яам хасчихсан гээд тэгээд одоо юу ч байхгүй юм уу. Үнэхээр юу ч байхгүй юм уу. Юу ч байхгүй юм уу тэгээд. Тэгээд яах юм. Тэгээд малчид яах юм. Мал аж ахуй яах юм.

Ц.Идэрбат: Энэ дээр хэн хариулах вэ. Энхбаяр сайд бол бүх хариултаа өгчихлөө шүү дээ.Тэгээд яагаад хассан талаар Эдийн засаг, хөгжлийн яамныхан хариулах уу. 4 номер. Нэр, албан тушаалаа хэлээд хариулаарай та.

Б.Төгөлдөр: Гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яам Төгөлдөр. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт нийт 20 төслийн санал ирсэн. Цахим системээр ирсэн. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл нь 30 тэрбум төгрөгөөс дээш өртөгтэй, ТЭЗҮ, зураг төсөл нь боловсруулагдсан. Урт, дунд хугацааны бодлоготой нийцсэн байх ба санхүүжилтийн бүх эх үүсвэр нь багтсан ийм байх төсөл ирсэн байх ёстой. Ирсэн төслүүдийг Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын тушаалаар баталсан “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах аргачлал”-ын дагуу үнэлж, эрэмбэлсэн. Тэгээд тус аргачлалын дагуу үнэлж эрэмбэлэхдээ бид нар 1 дүгээрт ач холбогдол, 2 дугаарт хэрэгжих боломж гэсэн 2 ерөнхий шалгуурын дагуу, 8 дэд шалгуурын дагуу үнэлж, нийт 8 төслийг тусгасан.

Энэ тусгасан 8 төсөл маань болохоор санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн дээр 5 төсөл тусгагдсан. Нийт 415,3 тэрбум .../минут дуусав/

Ц.Идэрбат: Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: Энхбаяр сайд аа, наад Төгөлдөр даргын чинь хэлж байгаагаар бол танай яамнаас өгсөн төслүүд чинь тэр 8 шалгуур үзүүлэлтийг нь хангаагүй юм биш үү. Тэгчхээд одоо энд ингээд чи хөдөө явж үзсэн үү, хөдөө явж үзээгүй юу гээд хүн загнаад байж болохгүй юм биш үү. Тэр шалгуур үзүүлэлтийг нь бүүр гаргаад ирээч Эдийн засгийн яамныхан. Тэгээд яг хэн нь худлаа яриад байгааг олж аваад, дандаа нэг ийм хөгжлийн хөтөлбөр эсвэл төсөв эд нар хэлэлцэхээр дандаа ийм сандал ширээний нэг ийм юмтай байгаад байх юм.

Ц.Идэрбат: 5 номер Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Би Их Хурлын баталсан тогтоолыг хэрэгжүүлж байгаа. Цагаан алт хөтөлбөр 2028 он хүртэл хэрэгжих бүр зүйл заалттайгаа, эх үүсвэртэйгээ. Хүнсний хувьсгал мөн адил. Атрын 4 дүгээр аян мөн адилхан. Энэ чинь дандаа нөгөө мөнгө нь зоогдоо, Их Хурлаар батлагдчихсан бодлогууд шүү дээ. Ингээд 2028 он хүртэл хэрэгжиж явж байгаа зүйлүүдээ гэнэт тайраад хаячихыг би ерөөсөө ойлгохгүй байгаа юм.

Тэгэхээрээ Их Хурлаар энийг батлуулахын тулд Монгол Улсын Ерөнхийлөгч санаачлаад, үндэсний энэ чинь бүүр зохион байгуулалтад ороод, үр дүнгүүд нь гараад бүгд бид нар хэлэлцэж байгаа шүү дээ. Тэгэхээр яагаад гэнэт ямар шалгуур гаргаад энийг тайраад, энэ хүнсээ хангах бодлого, хөдөө аж ахуйг эрчимжүүлэх, мал аж ахуйг эрсдэлээс хамгаалах, бэлчээрийн даацыг тохируулах, малын ашиг шимийг дээшлүүлэх энэ бодлого яагаад буруу болчхов гэдгийг л тайлбарлаад, би ерөөсөө ойлгохгүй болчихоод байгаа юм. Энэ чинь миний зохиосон, тэнгэрээс буусан санаа

биш шүү дээ. Энэ чинь 2028 он хүртэл Их Хурлаар батлагдаад, эрх барьж байгаа нам.../минут дуусав

Ц.Идэрбат: Баярлалаа. Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулах гэж байна уу та. 8 номер.

Л.Энх-Амгалан: Эдийн засаг, хөгжлийн яам Энх-Амгалан. Цагаан алт, Хүнсний хувьсгал гээд хөтөлбөрүүд бол бүгд хэрэгжээд явна. Энэ 5 жилийн хөтөлбөрийн оруулж ирсэн форматын хувьд бол яг нөгөө арга хэмжээг бол учиргүй тэгж задлахгүй байгаа юм. Эцсийн үр дүнг нь бол оруулчихсан байгаа. Энэ хөтөлбөрүүдийг бол огт хассан юм байхгүй. Бүгд хэрэгжээд явна. Жил болгоны хөгжлийн төлөвлөгөөндөө тухай тухайн ондоо аль хэсэг нь хэрэгжих вэ гэдэг нь ороод явах юм. 26 оны хөгжлийн төлөвлөгөөнд бол эд нар бүгд байгаа. Цаашдаа жил болгоны төлөвлөгөөндөө ч гэсэн байгаа. Энэ хөтөлбөрүүдийн үр дүн ингэж гарах ёстой шүү гэдэг ки пи ай үзүүлэлтүүдийг л тодорхой оруулж өгсөн байгаа. Тэрнээс биш хэрэгжээд явж байгаа үндэсний хөтөлбөрүүдийг огт хасаагүй, хэрэгжүүлээд явна гэдэг дээр угаасаа байр суурь нэг байгаа.

Ц.Идэрбат: Тэгээд баахан маргалдаж, маргалдаж байгаа юм шиг болчхов уу. Тэгэхээр ийм байна. Энэ хөгжлийн бодлого юмнуудаа оруулж ирэхдээ энэ чинь Засгийн газраа төлөөлөөд та нар өөдөөс хараад сууж байгаа шүү дээ. Тэгээд Засгийн газрын 2 яам нь байгаа, байхгүй гээд ингээд маргалдаад баймааргүй байгаа юм. Ер нь бол энэ Цагаан алт, Хүнсний хувьсгал гээд энэ хөтөлбөрүүдийг чинь бүр 2028 он хүртэл нь жил болгон тодорхой санхүүжилтийг нь тавина. 2028 онд ийм үр дүнд бид нар хүрчихсэн байх юм гэсэн яг л өнөөдрийн та бүхний яриад байгаа саяын тэр үр дүнг хэрхэн тодорхойлох вэ гэдэг тэр зүйлийг чинь аль 2023 онд нь батлаад, одоо хэрэгжүүлээд явж байгаа. Энэ хөтөлбөрийг цаашдаа хэрэгжинэ гэж бодож хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байгаа энэ олон малчин, тариаланчид, хөнгөн үйлдвэрт ажиллаж байгаа бүх хүмүүс чинь бизнес төлөвлөгөө юмнуудаа гаргачихсан явж байгаа шүү. Хэрвээ энэ төсөл хөтөлбөрүүдийг ингээд ямар нэгэн байдлаар энэ яамнууд хоорондоо үл ойлголцол болоод хасагдана гэсэн ийм зүйл бол байхгүй гэж би бас гишүүнийхээ хувьд хэлье гэж ингэж бодож байна.

Одоо Замира гишүүн.

С.Замира: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ сая Мөнхбаясгалан гишүүн асуулаа л даа. Эрчимжсэн мал аж ахуй гээд энэ 5 жилийн хугацаанд мал аж ахуйн системийг тэр чигээрээ эрчимжсэн юун дээр шилжүүлэх гээд байна уу. Энийг тодорхой хэлж өгөөч. Бэлчээрийн мал аж ахуйг яах вэ. Ер нь манай Монголд бол бэлчээрийн аж ахуй яг тохирсон байдаг шүү дээ. Тэгээд бэлчээрт уялдсан малын мах нь ч бас амттай байдаг. Энэ дээр 1 дүгээр хариулт авъя.

2 дугаарт энэ Энхбаяр сайдаас нэг юм тодруулмаар байна. Бид нар санаачлан баруун бүсийн гурилын үнэ, хивгийн үнэ тэглэж, татваргүй болгоно гээд баахан гишүүд гарын үсэг зураад өгсөн дөө. Энэ ажил ажил болохгүй одоо хүртэл хэвээрээ. Татвар төлж байгаа юм байна шүү дээ. Хивгийн үнэ 45 мянгад хүрчихсэн байна. Баян-Өлгий аймагт. Гурилын үнэ 110 мянга болсон байна. Тэгээд дотоодын аж ахуйн нэгжүүдийг дэмжинэ гэхээр нь бас ингээд ард түмний байдлыг нь харгалзахгүй, заавал ашгийг нь бодоод ингэтэл үнэ нэмэх шаардлага байсан юм уу. Энд нэг тодорхой хариулт өгөөч.

Ц.Идэрбат: 5 номерын микрофон. Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Бид нар уламжлалт мал аж ахуйгаа мэдээж бүх талаар дэмжиж, цаашид нь байхын төлөө байгаа. Гэхдээ чанаржуулах, ялангуяа малын үржил шим, ашигт байдлыг дээшлүүлэхгүй бол бид энэ өнгөрсөн 30-аад жил томоохон бодлогын алдаа гарчихсан. 1990 оны харьцуулахад бод 30-40 кг, бог 8-12 кг-аар давжаарчхаад байгаа юм шүү дээ. Тэгэхээрээ бид зайлшгүй малын үржил селекц, ашиг шимт малын тоог нэмэх үржил селекцийн бодлогыг хийнэ.

Үндсэн хуульд заасан мал сүрэг төрийн хамгаалалтад байна гэдэг гол заалт бол малын эрүүл мэндийн асуудал буюу мал эмнэлгийн үйлчилгээ, нөгөөдөх нь ашиг шимт байдлыг дээшлүүлэх, үржил селекцийн бодлого, төр хийх ёстой. Энэ ажлууд орхигдсонтой холбоотойгоор 1 малаас авах ашиг шим багассан. Ингээд тооны хойноос хөөцөлдөх ажил эхлээд, өнөөдөр бэлчээр 25 сая толгой малаар хэтэрчихсэн. Ингээд бэлчээрт талхлагдаад мал сүрэг маань эрсдэл авах чадавх нь буураад, тэжээлийн хүрэлцээ дутуу байгаа юм. Иймд энийг шийдэхийн тулд Атрын 4 дүгээр аянаар 200 мянга хүртэл га талбайг эргэлтэд оруулж, бүх улсын хэмжээнд тэжээлийн таримлыг эрс нэмэгдүүлэх. Тэгж байж энэ байгаль цаг уурын бэрхшээлийг даван туулах гэдэг асуудал гэдэг асуудал. Тэрнээс тэнгэр лүү гараад зуд гэж ярих биш. Тэжээл тарих, усжуулах ийм бодлогууд зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Хивэг, гурилтай холбоотой асуудал дээр Улсын Их Хуралд өргөн барьчихсан. Их Хурал яаралтай горимоор ойрын үед хэлэлцэнэ гэж Их Хурлын дэд дарга амласан. Тэр хүрээнд Их Хурлын мэдэлд ирсэн болохоор ойрын үед, ирэх 7 хоногтоо шийдчих байх гэж найдаж байна. Ингээд хивэг, гурилын зохицуулалтыг ялангуяа баруун 5 аймгийн 5 боомт дээр тодорхой хэмжээний квот олгоод, тогтвортой хангалт нийлүүлэлтийг хийх ажил нь засгаасаа гараад Их Хурлын түвшинд шилжчихсэн байгаа юм шүү. Ирэх 7 хоногтоо бүгдээрээ хамтраад шийдчих байх гэж.

Ц.Идэрбат: Гишүүд асуулт асууж дууслаа.

Одоо Их Хурлын гишүүдээс ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Зарчмын зөрүүтэй 12 санал, 2 гишүүнээс ирсэн байгаа.

1.Төслийн 2 дугаар хавсралтын үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн “НИЙГМИЙН ХӨГЖИЛ, ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ” бодлогын чиглэлийн 3.1.2 дахь дэд заалтын “хамтран хариуцагч” баганад “Боловсролын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мандхай. Санал хураалт. 18 гишүүн санал хураалтад оролцож, 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар хавсралтын үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн “НИЙГМИЙН ХӨГЖИЛ, ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ” бодлогын чиглэлийн 4.4.3 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам” гэсний дараа “, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мандхай. Санал хураалт. 12 гишүүн буюу 66,7 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар хавсралтын үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн “ЭДИЙН ЗАСАГ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ” бодлогын чиглэлийн 5.1.2.1 дэх дэд заалтын “Арга зам” баганад “нийлүүлэлтийн сүлжээг өргөтгөх” гэсний дараа “, хүний нөөцийг бэлтгэх /анхан, дунд, дээд шатад/, ажлын байрыг баталгаажуулах” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мандхай. Санал хураалт. Зарчмын зөрүүтэй гаргасан санал дээрээ Их Хурлын гишүүн Мандхай тайлбар өгөх юм байна. Мандхай гишүүний микрофон.

М.Мандхай: Ер нь хөдөө аж ахуйг цогцоор нь хөгжүүлэе гэх юм бол нийлүүлэлтийн сүлжээг өргөтгөх нь маш чухал ач холбогдолтой. Одоогийн байдлаар бол манайд яг анхан, дунд шатад бол ер нь энэ хүний нөөцийн бэлтгэлийн асуудал бол бас маш хүндрэлтэй байгаа. Ялангуяа жишээлбэл энэ мэргэжилтэн бэлтгэх, чанарын үнэлгээ, малын эмч, мал зүйч, ялангуяа энэ таваарын судлаач, технологийн мэргэжилтнүүд гэх зэрэг эдгээр ийм чухал ялангуяа энэ өртгийн сүлжээн дэх анхан, дунд шатан дахь мэргэжлийн боловсон хүчнийг бэлдэхгүй бол энэ өөрөө ерөөсөө яг цогцоороо хэрэгжих ийм боломжгүй.

Одоогийн байдлаар бол яг эцсийн үйлдвэрлэгч дээр бас чанартай хүний нөөц бол бэлтгэгддэг. Тийм учраас цогцоор нь бэлтгэх шаардлагатай байгаа учраас нээлтийн энэ сүлжээнд бас хүний нөөцийг бэлтгэх анхан, дунд, дээд шатдаа гэж бас оруулж өгсөн байгаа. Тэгээд дэмжээд өгөөрэй.

Ц.Идэрбат: Санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 72,2 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар хавсралтын үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн “ЭДИЙН ЗАСАГ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ” бодлогын чиглэлийн 5.3.1.2 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Шадар сайдын ажлын алба /Бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн/” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мандхай. Санал хураалт. 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 2 дугаар хавсралтын үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн “ЭДИЙН ЗАСАГ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ” бодлогын чиглэлийн 5.3.1.3 дахь дэд заалтын “Арга зам” баганад “Дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх” гэсний дараа “, хөрсний үржил шимийг сайжруулах, ган, чийгт тэсвэртэй үр сортыг бий болгож, тариалах” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мандхай. Санал хураалт. 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 2 дугаар хавсралтын үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн “ЭДИЙН ЗАСАГ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ” бодлогын чиглэлийн 5.4.1.1, 5.4.1.2 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Боловсролын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мандхай. Санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 72,2 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 2 дугаар хавсралтын үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн “БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ЭДИЙН ЗАСАГ” бодлогын чиглэлийн 6.3.1.1 дэх дэд заалтын “Арга зам” баганад “Олон талын оролцоонд суурилсан ой хамгааллыг дэмжих” гэсний дараа “, доройтсон бэлчээрийг ойжуулах ойн бэлчээр үүсгэн, уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах

шингээлтийг нэмэгдүүлэх” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мандухай. Санал хураалт. 13 гишүүн дэмжиж 72,2 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 2 дугаар хавсралтын үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн “БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ЭДИЙН ЗАСАГ” бодлогын чиглэлийн 6.3.1.2 дахь дэд заалтын “Арга зам” баганад “усны нөөц чийн зохистой ашиглалтыг дэмжих” гэсний дараа “, нэн ховор болон ховордсон загасыг унаган орчинд нь нөхөн сэргээх, үржүүлэх” гэж, “Хамтран хариуцагч” баганад “Эрчим хүчний яам” гэсний дараа “Боловсролын яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мандхай. Санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 72,2 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 2 дугаар хавсралтын үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн “БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ЭДИЙН ЗАСАГ” бодлогын чиглэлийн 6.3.1.5 дахь дэд заалтын “Арга зам” баганад “дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх” гэсний дараа “/Мал бордох аж ахуй, малчдын бууцаар органик бордоо үйлдвэрлэх цех, үйлдвэрүүдийг орон нутагт байгуулах, үйлдвэрлэсэн бордоогоор нь бэлчээр болон тариалангийн талбайн хөрсөө бордох, үржил шим, бүтээмжийг нэмэгдүүлэх/” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мандхай. Санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 72,2 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 2 дугаар хавсралтын үндсэн чиглэлийн үр. Дүнг тодорхойлсон хүснэгтийн “ЭДИЙН ЗАСАГ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ” бодлогын чиглэлийн 5.3.1.2 дахь дэд заалтын “Арга зам” баганад “Селекц, үржил, генетикийн хяналтыг сайжруулах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх” гэснийг “Бэлчээр тэжээлийн нэг болон олон наст ургамлын үрийн генфондыг бий болгох, үр үйлдвэрлэлийг хөгжүүлэх, тэжээлийн таримлын технологийг нэвтрүүлж, малын тэжээлийн баазыг бэхжүүлэх, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, шинжлэх ухааны үндэслэлтэй тэжээл үйлдвэрлэлийг хөгжүүлж, нэгж бүтээгдэхүүнд зарцуулах тэжээлийн зардлыг бууруулахад чиглэсэн дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх, нутагшуулах” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мандхай. Санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 72,2 хувиар санал дэмжигдлээ.

11.Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 6.3.1.6 дахь дэд заалт нэмэх:

Төслийн 2 дугаар хавсралтын үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн “БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ЭДИЙН ЗАСАГ” бодлогын чиглэлийн “Дугаар” баганад “6.3.1.6” гэж, “Бодлогын үндэслэл” баганад. “АХ-6.3” гэж, “Салбар” баганад “71404 Усны нөөц, нуур, гол мөрний менежмент” гэж, “Үр дүн” баганад “Экологийн тогтвортой байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн хөв цөөрөм, усан сан, нуур байгуулна.” гэж, “Арга зам” баганад “333 нуур-нэг сум, нэг нуур-усны нөөцийн хуримтлал бий болгож уур амьсгалын өөрчлөлтөөс сэргийлэх” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам” гэж, “Хамтран хариуцагч” баганад “Усны газар” гэж, 3 дугаар хавсралтын үндсэн чиглэлийн хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг тодорхойлсон хүснэгтийн “БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ЭДИЙН ЗАСАГ” бодлогын чиглэлийн “Дугаар” баганад “6.3.1.6” гэж, “Салбар” баганад “71404 Усны нөөц, нуур, гол мөрний менежмент” гэж, “Үр дүн” баганад “Экосистемийн тогтвортой байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн хөв цөөрөм, усан сан, нуур” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Шинээр байгуулсан хөв цөөрөм, усан сан, нуур” гэж, Тогтвортой хөгжлийн зорилтын уялдаа баганад “13.1” гэж, “Хэмжих нэгж” баганад “Тоо” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2025, Түвшин: 4” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026 онд 54, 2027

онд: 104, 2028 онд: 154, 2029 онд: 204, 2030 онд 259” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Мэдээлэх, цуглуулах арга зүй: Салбарын статистик, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаясгалан. Санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 72,2 хувиар санал дэмжигдлээ.

12.Төслийн 4 дүгээр хавсралтын 4.3 дахь хэсэгт заасан жагсаалтад доор дурдсан агуулгатай 13 дахь мөр нэмэх:

“НОГООН ХӨГЖИЛ” хэсгийн “Дугаар” баганад “13” гэж, “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “333 нуур-нэг сум, нэг нуур-усны нөөцийн хуримтлал” гэж, “Байршил” баганад “Улсын хэмжээнд” гэж, Санхүүжилтийн хугацаа” баганад “2026-2030”, “Төсөвт өртөг” баганад “201,600.0” гэж, “Хариуцагч” баганад “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Их хурлын гишүүн Мөнхбаясгалан. Санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 72,2 хувиар санал дэмжигдлээ.

Одоохон дууслаа. Тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж дууслаа.

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хороонд Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга танилцуулна.

Хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

13.12 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ